

АГУУЛГА

НЭГ. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА:

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГАА:

ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦ.

ДӨРӨВ. ИЛ ТОД БАЙДАЛ

- Цахим мэдээ, мэдээллийн ил тод байдал
- Бүртгэлийн үйлчилгээний ил тод байдал

ТАВ. СУРГАЛТ

- Албан хаагчдад чиглэсэн сургалт
- Иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн сургалт

ЗУРГАА. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

ДОЛОО. БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Бүртгэл хяналтын чиглэлээр
- Иргэний улсын бүртгэл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл

НАЙМ. САНХҮҮ

ЕС. БУСАД

АРАВ. ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 06 дүгээр
сарын 07 -ны өдөр

Чойбалсан хот

НЭГ.ОРОН НУТАГТ УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР ХҮНДИЙГ
ӨНДӨРТ ӨРГӨЖ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАА УХАМСАРЛАХ АЖЛЫН
ХҮРЭЭНД


❖ Тус хэлтэс нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан бодлогын бичгүүдийг танилцуулах нээлтийн арга хэмжээний хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг Цагдаагийн газартай хамтран идэвхи санаачлагатай, үр дүнтэй зохион байгуулсныг үнэлэн аймгийн Цагдаагийн газраас “Талархал” гардуулав.



❖ Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах зорилго бүхий “АРХИГҮЙ ДОРНОДЫН ТӨЛӨӨ” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “АРХИГҮЙ АМЬДРАЛЫГ БИД ХҮСНЭ” АСК тэмцээнд амжилттай оролцов.



- ❖ 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар **“ЗӨРЧИЛГҮЙ”** дүгнэлт авсан.



- ❖ Жил бүрийн 3 сарын сүүлийн долоо хоногийн пүрэв гаригт 16 цагаас зохион байгуулагддаг онцгой бэлэн байдлын дуут дохиот дадлага сургалтанд тус хэлтэс хамрагдаж, дадлага сургуулилтыг гүйцэтгэв.



- ❖ Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ахмаддаа “Сар шинийн баяр”-ыг угтаж үндэсний үйлдвэрийн сүү, сүүн бүтээгдэхүүнээр бэлэг барив.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

- ❖ “Боловсрол экспо-2019” өдөрлөгт оролцож шинээр 16 нас хүрсэн иргэдэд цахим иргэний үнэмлэх гардуулж, “ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав.



- ❖ Бүх нийтийн биеийн тамир, спортыг дэмжих зорилгоор жил бүрийн 5 дугаар сарын 3 дахь долоо хоногийн Бямба гаригт зохион байгуулдаг “Дорнод марафон” гүйлтийн тэмцээнд хэлтсийн хамт олон амжилттай оролцов.




- ❖ Тус аймгийн хүүхдийн “ANNA HOME” асрамжийн газрын барилга шатаж асар их хохирол амссан бөгөөд аймаг орон нутгаас “Мөрөөдлийн байшин” аянг зарласан бөгөөд тус аянд хэлтсийн албан хаагчид нэгдэж хандив өгөв.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

- ❖ 2012 онд тус аймгийн Баяндун суманд гарсан түймэрт өртөж 70 хувийн түлэгдсэн 260.0 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.



- ❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/130 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын “Чойбалсан хотын ногоон хөгжлийн чиг баримжаатай хот болгон хөгжүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” зорилгын хүрээнд эх орон байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, нөхөн сэргээх бүтээлч ажилд хэлтсийн албан хаагчид хамрагдав.



- ❖ Аугаа их эх орны дайны ялалтын 74 жилийн ойг тохиолдуулан Чойбалсан хотын Бунхан толгой дахь “Зөвлөлийн нисгэгчдийн хөшөө”-нд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд хэлтсийн албан хаагчид хамрагдав.



ХОЁР.ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД


2019 онд хийж хэрэгжүүлэх ажил, үүрэгтэй холбоотойгоор аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан нийт 28 арга хэмжээ, тусгайлан сонгосон 28 арга хэмжээний биелэлтийг ханган ажиллаж байна.



Мөн төрийн байгууллага, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах төлөвлөгөө, тулгамдаж буй асуудлаар Аймгийн ЗДТГ-ын 2019 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн шуурхай хуралдаанд мэдээлэл хийж ажилласан. Тус хэлтэс нь Аймгийн Засаг даргын тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн дэх газар, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүүхэд гэр, бүл хөгжлийн газар зэрэг байгууллагуудтай өдөр тутмын үйл ажиллагаагаар хамтран ажиллаж байна.



- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр тус аймгийн Хөлөнбуйр, Сэргэлэн, Гурванзагал, Баянтүмэн, Матад, Баяндун, Чойбалсан, Булган зэрэг 8 сумыг иргэний улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбох 25.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн бөгөөд хэрэгжилт 60 хувьтай явагдаж байна.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

❖ Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл”-ийн гишүүд тус хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцов.



❖ Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан “Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад зөвлөн туслах арга хэмжээ”-ний удирдамжийн хүрээнд Хууль, хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр “Анхаарах асуудал, шийдлийн талаар” мэдээлэл, танилцуулга хийж ажиллав.



❖ Монгол Улсын Хууль, зүй дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албадын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор гаргасан Хууль, зүйн сайдын 1/1210 тоот албан даалгаврын дагуу “Хууль сахиулах байгууллагуудын удирдлагын хамтарсан уулзалт”-нд хэлтсийн дарга оролцож тулгамдаж буй асуудлаар санал солилцов.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

- ❖ Хууль хяналтын байгууллагад хуулийн хүрээнд тайлант хугацаанд албан бичгээр 314 лавлагаа олгож ажилласан.
- ❖ Тайлант хугацаанд аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт шинээр төрсөн 799 хүүхэд, нас барсан 214 иргэн, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нас барсан 214 иргэн, Хүүхэд гэр, бүл хөгжлийн газарт 19 хүүхдийн үрчлэлтийн судалгаа, мэдээллийг тус тус гарган сар бүрийн 25-нд хүргүүлж хамтран ажиллаж байна. Мөн иргэдийн шилжилт хөдөлгөөний хянах зорилгоор шилжин явсан иргэдийн судалгааг жагсаалтаар сарын бүрийн 25-нд сумын Засаг даргын тамгын газарт гарган өгч хамтран ажиллаж байна.

ГУРАВ.ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 08 сарын 24-ны өдрийн Б/89 тушаалаар хэлтсийн бүтэц, орон тоо батлагдаж төрийн захиргааны албан хаагч -25, төрийн үйлчилгээний ажилтан -4, гэрээт -2 нийт 31 албан хаагчтайгаар аймгийн 81 мянга гаруй иргэнд төрийн бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.



- ❖ Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, Монгол улсын “Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ” 2005:5538 стандарт, “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих”, “Биеийн тамир, спортыг бүх нийтийн хэрэглээ болгоцгооё” жилийн хүрээнд “Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-д байгууллагын албан хаагчдаа бүрэн хамруулж, сорилын 9 төрлөөр өөрсдийн бие бялдрын түвшинг тодорхойлж, үнэлгээгээ тогтоолоо.



❖ Аймгийн Биеийн тамир, спортын газраас төрийн албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан “Хамт олноороо бадминтон тоглоцгооё” өдөрлөгт амжилттай оролцов.



❖ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол Цэргийн өдрийг тохиолдуулан албан хаагчдаа баярлуулав.



➤ Албан хаагчдын 2-12 насны 29 хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг шүдний СУПЕРДЕНТ эмнэлэгтэй хамтран үнэ төлбөргүй зохион байгуулсан.




- Итгэл Ивээлт эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг урьдчилан сэргийлэх ЭХО аппарат болон зүрхний цахилгаан бичлэг хийлгүүлэхээр болсон бөгөөд үзлэгийн төлбөрийн асуудал шийдвэрлэлтийн шатандаа явагдаж байна.
- УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн захиргааны 15 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийн зөрүүг, Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор 29 албан хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн тогтоож, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/178 тоот тушаалаар 2 гэрээт ажилтны цалинг шинэчлэн тогтоосон. Мөн хэлтсийн даргын 2018 оны А/30 дугаар тушаалаар 2018 оны үр дүнгийн гэрээний биелэлтээр А үнэлэгдсэн төрийн захиргааны 6 албан хаагчийн албан тушаалын цалингийн шатлалыг 2019 оноос ахиулсан.
- Хүний нөөцийн ажлын хэсэг ажилласан жилийн, шагналын, орон сууцны, хүүхдийн, албан тушаал сэлгэн ажиллах, ажлын байр өөрчлөх, Мэргэжил дээшлүүлэх болон сурч боловсрох зэрэг судалгаануудыг шинэчлэн авч сан үүсгэн ажилласан.
- Чойбалсан сумын улсын бүртгэгчийн түр орон тоо, Цагаан-овоо сумын улсын бүртгэгчийн сул орон тооны мэдээллийг байгууллагын www.ubh.dd.gov.mn цахим сайт, Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн фэйсбүүк хуудсанд тухай бүр байршуулж ажилласан.
- Ажилд орохыг хүссэн 4 иргэнээс материал хүлээн авч мэдээллийн санд бүртгэн, төрийн албаны шаардлага хангасан 1 иргэнийг Цагаановоо сумын улсын бүртгэгчээр томилуулах саналыг хүргүүлж, улмаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/213 дугаар тушаалаар туршилтын хугацаанд улсын бүртгэгч томилогдон ажиллаж байна.
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 30 албан хаагчдийн хувийн хэргийг шинэчлэн баяжилтыг хийж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтэс хэлтсийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 343 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Албан хаагчдын ажил үүргийн давхардалыг арилгах зорилгоор хэлтсийн даргын тушаалаар 12 ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Үүнд:
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл

- Авлигын эсрэг орон тооны бус зөвлөл
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах орон тооны бус зөвлөл
- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл
- Терроризмоос урьдчилан сэргийлэх ажлын хэсэг
- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг
- Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний баг
- “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг хангах ажлын хэсэг
- Биеийн тамир спорт, эрүүл мэндийг дэмжих ажлын хэсэг
- Сургалт хариуцсан ажлын хэсэг
- Баримт бичиг нягтлан шалгах комисс
- Эцэг, эхийн зөвлөл зэрэг ажлын хэсгүүдийг байгуулсан.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 9/2107 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын www.ubh.dd.gov.mn цахим сайтыг “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах заавар чиглэл”-ийн дагуу шинэчилж ажилласан.



Үүнд: Байгууллагын цахим сайтыг 7 үндсэн цэс 40 дэд цэс болгож шинэчилсэн.

1. Эхлэл



2. Бидний тухай
 - 2.1. Мэндчилгээ
 - 2.2. Танилцуулга
 - 2.3. Түүхэн замнал
 - 2.4. Зорилго, зорилт
 - 2.5. Тэргүүлэх чиглэл
 - 2.6. Стратегийн зорилт
 - 2.7. Тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл
3. Мэдээ, мэдээлэл
 - 3.1 .Видео мэдээ
 - 3.2 Сумдууд /14 сум орсон /
4. Бүртгэлийн үйлчилгээ /бичиг баримтын бүрдүүлэлт, үнэ хураамжийн талаарх мэдээлэл/
 - 4.1. Иргэний бүртгэл
 - 4.2. Эд хөрөнгийн эрхийн бүртгэл
 - 4.3 Хуулийн этгээдийн бүртгэл
5. Хууль тогтоомж
 - 5.1. Улсын бүртгэлийн багц хуулиуд
 - 5.2. Хууль зүйн сайдын тушаал
 - 5.3. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол
 - 5.4. Бүртгэл хөтлөх журам
 - 5.5. Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бусад хуулиуд
 - 5.6. УБЕГ-ын даргын тушаал
 - 5.7. Хэлтсийн даргын тушаал
 - 5.8. Нийтлэг дүрэм, журам
6. Байгууллагын ил тод байдал
 - 6.1. Өргөдөл, гомдол хүлээн авах
 - 6.2. Хэлтсийн даргын иргэдийг хүлээн авах цагийн хуваарь
 - 6.3. Хүний нөөцийн ил тод байдал
 - 6.4. Санхүүгийн ил тод байдал
 - 6.5. Шилэн данс
 - 6.6. Статистик тоон мэдээ
7. Үйлчлүүлэгч таньд
 - 7.1. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ
 - 7.2. Байгууллагын үйлчилгээний стандарт
 - 7.3. Статистик тоо мэдээ
 - 7.4. Төлөвлөгөө
 - 7.5. Тайлан
 - 7.6. Хүчингүй бичиг баримт
 - 7.7. Түгээмэл асуулт хариулт

Байгууллагын цахим сайт www.ubh.dd.gov.mn болон Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк www.facebook.com/ubh.dornod группээрээ дамжуулан

олон нийтэд мэдээ, мэдээллийг тогтмол түгээн сурталчлан ажиллаж хэвшээд байгаа бөгөөд 2019 оны эхний хагас жилийн байдлаар цаг үе, үйл явдалтай холбоотойгоор 53, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах чиглэлээр цахим хуудсаар хууль сурталчлах 95 баннер, зурагт мэдээлэл байршуулж, цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 58 иргэнд зохих мэдээлэл, тайлбарыг хүргэж ажилласан ба өнөөдрийн байдлаар 663083 хандалт хийгдсэн байна.



Мөн WWW.facebook.com/UBh.dornod/ хуудсанд “Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс” мэдээлэл сурталчилгааг иргэдэд хүргэн ажиллаж байна. Одоогийн байдлаар **2484** дэмжигчидтэй байна.

БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

Тус хэлтэс нь 2019 оныг “ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ” –ний жил болгон зарласан бөгөөд зорилтот жилийн хүрээнд 18 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

БАТЛАВ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГА
Д.ОЮУНБАЯР
3363817 2116129005



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСИЙН “ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ”
ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.03.13 Хэрлэн сум

Зорилго. МУ-ын ЗГ-аас “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жил болгон зарласантай холбогдуулж, тус хэлтэс зорилтоо ийнхүү дэвшүүлсэн бөгөөд Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг нэвтрүүлэх, УБЕГ-аас бүртгэлийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр барьж буй бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, иргэн-үйлчлүүлэгч бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээний талаарх мэдээллийг өөрт хамгийн ойр эх сурвалжаар тогтмол авч мэдлэгээ дээшлүүлэх, цахим хэлбэрээр үзүүлж болох үйлчилгээ, боломжийг нэмэгдүүлж, иргэдээс гарах зардал чирэгдлийг бууруулах, цаг хугацааг хэмнэхэд чиглэгдэнэ.

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН	ХҮРЭХ ҮР ДҮН
НЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР				
1.	УБЕГ-аас “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд аймгийн 8 сумыг иргэний бүртгэлийн онлайн сүлжээнд холбох.	Жилдээ	Хэлтсийн дарга Д.Оюунбаяр	Иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бүртгэлийн үйлчилгээг авах боломжтой болсон байна.
2.	Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй иргэдийн цахимаар ирүүлсэн хүсэлтийн дагуу “Иргэн таны гэрт, гэрт” гэрээр үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх.	3 сарын 15-ны өдрөөс эхлэн цаашид тогтмол	Улсын бүртгэгч М.Галбадрах Улсын бүртгэгч П.Шижирбаатар	Дээрх хүндэтгэн үзэх шалтгаантай иргэд бүртгэлийн үйлчилгээг ямар нэгэн зардал гаргахгүй, цаг алдалгүй гэрээр авах боломж бүрдсэн байна.
3.	Хэлтсийн вэб сайтын “Онлайн лавлагааны систем” булангийн үйл ажиллагааг сайжруулах, үндэсний энгийн гадаад паспорт, иргэний үнэмлэх, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, газрын гэрчилгээ зэрэг баримт бичгийн хэвлэлтийн талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэх.	Тухай бүр	Улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг Улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг	Орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэд онлайн сүлжээгээр өөрийн регистрийн дугаарыг ашиглаж захиалсан гэрчилгээ, иргэний цахим үнэмлэх, гадаад паспорт хэвлэгдсэн эсэх талаар мэдээлэл авах боломжтой болсон байна.
4.	16, 25, 45 насны иргэдийн судалгааг үндэслэн багийн ажлын албатай хамтран иргэний үнэмлэх шинээр захиалах болон сунгалтын мэдээлэл	Сар бүр	13 сумын улсын бүртгэгчид	Тухайн иргэд энэ талаарх мэдлэггүйгээсээ шалтгаалж өөрсдөө хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсооно.


❖ Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлж буй иргэн бүрийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, үйлчилгээний соёл, сэтгэл ханамжийн баталгааг өндөржүүлж, харилцааны болон үйлчилгээний зөрчилгүй хамт олон болох зорилгоор **“УГТАХ, ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 1021 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч чиглүүлэн ажиллаж байна.



❖ Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг хэрэгжүүлж, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх зорилгоор **“ИРГЭН ТАНЫ ГЭРТ, ГАРТ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г нэвтрүүлэн ажиллуулж байна. Энэхүү үйлчилгээгээр өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гадаад паспорт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, цахим иргэний үнэмлэх, лавлагаа зэргийг гэрт нь хүргэн өгдөг бөгөөд тайлант хугацаанд 36 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.



- ❖ Интернет орчинг идэвхитэй ашигладаг үйлчлүүлэгч иргэд байгууллагын www.ubh.dd.gov.mn цахим сайтын “ОНЛАЙН ЛАВЛАГААНЫ СИСТЕМ”-ээр гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ зэргийг хэвлэгдсэн эсэхийг регистрийн дугаараараа шалгах боломж бүрдсэн бөгөөд тайлант хугацаанд 367 иргэний мэдээллийг тус системд шивж оруулсан байна.



- ❖ Иргэдийн хэвлэгдэн ирсэн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэхийг “МЕССЕЖ ҮЙЛЧИЛГЭЭ”-ээр мэдээллийг хүргэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 367 иргэд мессеж мэдээллийг хүргэн ажилласан байна.




- ❖ Иргэд байгууллагын “НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970” дугаарт холбогдон бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах боломжтой бөгөөд тайлант хугацаанд 343 иргэн үйлчлүүлсэн байна.



- ❖ Байгууллагын WWW.UBH.DD.GOV.MN цахим сайтаар дамжуулан байгууллагын бүртгэлийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах зорилгоор мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



❖ “ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС” Facebook /ubh.dornod/ хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэхээс гадна онлайн чатаар иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 58 иргэний сонирхсон асуултанд хариулж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



❖ Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор Голомт банктай хамтран “**ПОС ТЕРМИНАЛ**” машин ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 325 иргэнд үйлчилсэн.



❖ Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор мэдүүлэг хүлээн авах цонхонд үйлчилгээний дансны дугаар болон улсын бүртгэгч нарын ажил үүргийн хуваарийг шинэчлэн ажиллаж байна.



❖ Байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын самбарт мэдээллийг тогтмол болон байнга шинэчлэх зориулалттай ухаалаг самбарыг байршуулан ажиллаж байна.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР:

Орон нутгийн хэвлэл мэдээллийн томоохон нэгж болох Мижи ТВ-тэй байгуулсан гэрээний дагуу шинэ хуулийн талаар сурталчилгаа мэдээллийг 20 удаагийн давтамжтай, нийт 65 реклам сурталчилгааг нэвтрүүлж хамтран ажилласан байна. Мөн түүнчлэн “D” телевизд “Цахим иргэний үнэмлэх болон шилжилт хөдөлгөөний бүртгэл”-ийн талаархи шинэ хуулинд гарсан өөрчлөлт, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой заалтын талаар 3 удаа зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



ТАВ.СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

НЭГ. АЛБАН ХААГЧДАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтэс нь өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 23 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 197 албан хаагч хамрагдахаас 181 албан хаагч хамрагдсан. Ирц 92 хувьтай. Үүнд:

1. Дорнод аймгийн төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн “Хандлага-Өөрчлөлт” нэртэйгээр зохион байгуулагдаж, тус хэлтсээс дарга Д.Оюунбаяр, улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг, улсын бүртгэгч Ц.Энхмаа нар хамрагдаж, төрийн албан хаагчдын хандлага, хариуцлагын чиглэлээр 2 өдрийн лекц сургалтанд хамрагдсан.



2. Алба хаагчдын суралцах арга барилыг сайжруулах чиглэлээр Mind Up сургалтын төвөөс зохион байгуулж буй “Суралцах ур чадвар” сэдэвт сургалтанд хэлтсийн нийт алба хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.



3. Аймгийн Прокурорын газраас “Албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт авч, хэлтсийн 11 албан хаагчийг хамруулсан.



4. Аймгийн Замын цагдаагийн газраас замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, хэлтсийн алба хаагчид бүрэн хамрагдав.



5. Аймгийн Татварын хэлтсээс Татварын шинэчилсэн хууль тогтоомж, цахимаар төлбөрийн даалгавар, нэхэмжлэх үүсгэх чиглэлээр сургалт зохион байгуулж, хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдав.



6. Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бөгөөд тус зөвлөгөөнд хяналтын улсын байцаагч Л.Сугаррагчаа хамрагдаж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн.



7. Дорнодын залуус ТББ-аас зохион байгуулсан Манлайлагч залуусын сургалтанд хэлтсийн Бичиг хэргийн эрхлэгч Т.Сэржмаа, архивч С.Батчимэг нар хамрагдав.



8. Аймгийн ЗДТГ, Дорнод их сургуулиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-нд улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг, улсын бүртгэгч Ц.Энхмаа нар хамрагдав.



9. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан нийгмийн даатгалын чиглэлээр шинээр нэвтрүүлсэн үйлчилгээ “Нийгмийн даатгал” аппликэйшнийг танилцуулах сургалтанд хэлтсийн төвийн алба хаагчид бүрэн хамрагдсан.

10. Аймгийн ЗДТГ, Дорнод их сургуулиас зохион байгуулсан Төрийн алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хүрээнд Хүний нөөцийн асуудал хариуцсан алба хаагчдад зориулсан сургалтанд архивч С.Батчимэг хамрагдаж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн.



11. Аймгийн ХГБХГ-аас зохион байгуулсан “Багийн хамтын ажиллагаа, харилцаа холбоо” сэдэвт сургалтанд ЭХЭУБТ-ийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг хамрагдсан.

12. МУ-ын Төрийн албаны зөвлөлийн захиалгаар Канадын Мерит төслөөс Дорнод аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах, ажлын байрны дүн шинжилгээ хийх” сургалтанд Ахлах нягтлан бодогч З.Сарантуяа, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Ж.Ганзориг нар хамрагдсан.

13. Мэдээллийн аюулгүй байдал болон кибер аюулгүй байдлын талаар алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ТЕГазраас зохион байгуулсан “Төрийн болон албаны нууцыг хамгаалах”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах”, “Кибер

гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх” сэдвээр тус тус 2 удаагийн сургалт хийж тус хэлтсийн 8 албан хаагч хамрагдсан.




14. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан “Үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт” сэдэв сургалтанд Хэлтсийн дарга Д.Оюунбаяр, Улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Болор-Эрдэнэ нар хамрагдсан.

15. Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг “Авилга, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр бие даан судалж, алба хаагчдад сургалт зохион байгуулав. Сургалтанд 8 албан хаагч хамрагдсан.



16. УБЕГ-ын даргын 2019 оны Б/43 тоот тушаалаар ЭХЭУБТ-ийн улсын бүртгэгчээр томилогдсон Н.Гантуяа, 2019.05.15-ны Б/213 тоот тушаалаар ИУБ-ийн улсын бүртгэгчээр томилогдсон Г.Нарантуяа нарын ажлын байран дахь сургалтыг зохион байгуулав.



17. УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Л.Сугаррагчаа 2 удаа, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Болор-Эрдэнэ 1 удаа тус тус хамрагдав.

18. УБЕГ-ийн Иргэний Улсын бүртгэлийн газраас зохион байгуулагдсан “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” төслийн сургалтын хүрээнд Иргэний Улсын бүртгэлийн тасгийн дарга улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг 14 сумын улсын бүртгэгч нарт онлайн сургалт хийв.

19. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг “Байгууллагын үйлчилгээний стандарт, ёс зүй” сэдвээр албан хаагчдад сургалт зохион байгуулав. Сургалтанд нийт албан хаагчид бүрэн хамрагдав.



20. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч Б.Шижирбаатар “Албан хэрэг хөтлөлт” сэдвээр албан хаагчдад сургалт зохион байгуулав. Сургалтанд 8 албан хаагчид хамрагдсан.



21. УБЕГ-аас зохион байгуулагдсан БНСУ-ын Шүүхийн харъяа төрийн албан хаагчдын сургалтын төвд Цахим бүртгэлийн үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн системтэй танилцах туршлага судлах сургалтанд Хэлтсийн дарга Д.Оюунбаяр хамрагдав.



22. 2019 оны 5 сарын 30, 31-ний өдрүүдэд УБЕГ-ийн Иргэний Улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох төсөл” сургалтанд Иргэний Улсын бүртгэлийн тасгийн дарга улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг, Хэрлэн сумын Улсын бүртгэгч Б.Болорцэцэг, Иргэний улсын бүртгэгч Ц.Энхчимэг, нярав, бичиг хэргийн ажилтан Т.Сэржмаа нар хамрагдав.



23. УБЕГ-аас 21 аймаг, 9 дүүргийн Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдад Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/91 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд “Оффисын ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа” сэдэвт онлайн сургалтыг зохион байгуулав.



ХОЁР. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЧИГЛЭСЭН ЭРХ ЗҮЙН
СУРГАЛТ МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн багц хууль, шинээр нэвтэрсэн үйлчилгээ, тус хэлтсээс 2019 онд дэвшүүлсэн “Иргэнд ойр бүртгэлийн цахим үйлчилгээний жил” зорилтот жилийн ажлын талаар нийт 7168 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Аймгийн нийгмийн асуудал хариуцсан төрийн байгууллагуудын хамтарсан сургалтын баг бүрэлдэхүүнд багтаж, Хэрлэн сумын 10 багуудад 4 удаагийн сургалтаар нийт 500 гаруй иргэдийг хамруулж, мэдээлэл хүргэж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч ажилласан.



2. Дээрх сургалтыг сумдад үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд Чойбалсан, Гурванзагал, Баянтүмэн сумдын нийт 760 гаруй иргэдэд мэдээлэл хүргэж, сонирхсон асуултанд хариулт өгөв.



3. Хэрлэн сумын ЗДТГ мэдээлэл хүргэж, сонирхсон асуултанд хариулт өгч ажилласан. Сургалтанд нийт 45 албан хаагч хамрагдсан.



4. 2019 оны 01 дүгээр сарын 28-ны аймгийн Удирдах ажилтны шуурхай хуралдаанд Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулгаар мэдээлэл хийж, сонирхсон асуултанд хариулав. 70 албан хаагч хамрагдсан.



5. 2019 оны 01 дүгээр 29-ны өдөр БОЭТөвийн ажилчин албан хаагчдад Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулгаар мэдээлэл хийж, сонирхсон асуултанд хариулав. 43 албан хаагч хамрагдсан.



6. 2019.03.26-ны өдөр Хэрлэн сумын багийн Засаг дарга болон нийгмийн ажилтан нарт Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулгаар мэдээлэл хийж, тус байгууллагуудын албан хаагчдын асуултад хариулт өгч ажилласан. Сургалтанд 20 албан хаагч хамрагдсан.



7. “Шүр” захын худалдаа эрхлэгчид болон БОЭТөвөөр үйлчлүүлж буй иргэдэд Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа болон иргэний улсын

бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 160 иргэнд мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч сонирхсон асуултанд хариулж, гарын авлага, боршурыг тараан ажилласан.



8. Тус аймгийн 14 сумын улсын бүртгэгч сумынхаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд Улсын бүртгэлийн багц хууль, шинээр нэвтэрч буй үйлчилгээний талаар нийт 5570 иргэнд зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажилласан.



ГУРАВ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАГЦ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР.

Тус хэлтсээс Улсын бүртгэлийн багц хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах ажлын чиглэлээр аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан өдөрлөг арга хэмжээнүүдэд оролцож дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Хууль зүйн яамны харъяа агентлагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож мэдээлэл хүргэж, 21 иргэний сонирхсон асуултанд хариулт өгөв.



2. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Хэрэглэгчээ сонсоё” нээлттэй хаалганы өдөрлөгт тус хэлтэс оролцож, нийт 25 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан.



3. Аймгийн ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээлэл өгөх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Боловсролын экспо-2019” өдөрлөгт бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилж, шинээр 16 нас хүрсэн иргэдэд иргэний цахим үнэмлэхийг гардуулж, “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.



4. Монголын Нотариатчидын тэнхимээс зохион байгуулсан Хууль сахиулах байгууллагуудын хууль сурталчлах “Про боно” өдөрлөгт оролцон, мэдээ мэдээлэл өгч, сонирхсон асуултанд хариулж, гарын авлага, боршурыг тараан ажилласан.



ЗУРГАА.ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан 477 санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэж хариу өгч ажилласан. Дээрх санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг ангилвал:

- Нээлттэй утас 98970970 дугаарт -343
- Санал хүсэлтийн дэвтэрт -16
- Санал хүсэлтийн хайрцагт -6
- Биечлэн хандсан -75
- Бичгээр -33
- ЗДТГ-ын 70582233 Нээлттэй утсанд -3
- Хэлтсийн цахим хаягаар -1

Байгууллагад ирсэн 477 санал, хүсэлт, өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж үзвэл гомдол -5 буюу 1.1%, талархал-17 буюу 3.57%, санал, хүсэлт, өргөдөл-34 буюу 7.1%-ийг эзлэж бөгөөд бусад 421 буюу 88.2% тус тус эзэлж байна.

➤ Байгууллагын Нээлттэй утас 98-970-970 дугаарт 343 иргэн хандсан ба үүнд: иргэний улсын бүртгэлтэй холбоотой 283 буюу 82.5%, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 21 буюу 6.1%, Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 39 буюу 11.3 % зөвлөгөө, мэдээллийг иргэнд хүргэж ажилласан байна.

➤ Аймгийн ЗДТГ-ын “Нээлттэй утас” 7058-2233 дугаарт 3 иргэн хандаж өргөдөл, гомдол гаргаснаас иргэний бүртгэлтэй холбоотой 2 буюу 66.7%, албан хаагчидтай холбоотой 1 буюу 33.3%-ийг тус тус эзэлж байна.

➤ Санал хүсэлтийн дэвтэрт 16 иргэн санал, хүсэлт, гомдлоо илэрхийлснээс талархал 14 буюу 87.5%, гомдол 1 буюу 6.2%, хүсэлт 1 буюу 6.2% тус тус эзэлж байна.

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

- Санал хүсэлт хүлээн авах хайрцагт 6 иргэн санал, хүсэлт, гомдлоо илэрхийлснээс талархал 3 буюу 50%, гомдол 2 буюу 33.3%, хүсэлт 1 буюу 16.7% тус тус эзэлж байна.
- Бичгээр гаргасан 33 өргөдлийг ангилбал: Чөлөө хүсэх тухай 1 буюу 3%, албан хаагчтай холбоотой 1 буюу 3%, бүртгэлийн зөрчилтэй холбоотой 16 буюу 29.1%, гадаад паспортын талаар 2 буюу 6.1%, улсын бүртгэгчтэй холбоотой 1 буюу 3%, тэмдэгтийн хураамжийн буцаалт 4 буюу 7.28%, төрсөн эх нас барсан тухай тэтгэмж 1 буюу 3%, сумын улсын бүртгэгч ажилд авах тухай 2 буюу 6.1%, ажилласан жилийн лавлагаа авах тухай 2 буюу 6.1%, хүний нөөцтэй холбоотой 2 буюу 6.1%, ЭХЭБ-ийн гэрчилгээ шалгуулах тухай 1 буюу 3%-ийг тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдлын тайланг улирал тутам гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.

ДОЛОО.БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

➤ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3667 бүртгэлийг хянаж шалгаснаас Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 3047 буюу 83.1%, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 350 буюу 9.5%, Хуулийн этгээдийн улсын бүртгэл 120 буюу 3.28%, 150 архив буюу 4.9% бүртгэлүүдийг архивын хувийн хэрэг эх нотлох баримтыг татаж шалгаж ажилласан.




Тайлант хугацаанд Хэрлэн сумын улсын бүртгэгчийн бүртгэлийн үйл ажиллагаа 1153 бүртгэлийн, нотлох баримт бүрдүүлбэрийг бүртгэлийн дэвтэр, онлайн санд шалгаж 9 зөрчлийг илрүүлэн, тухайн шатанд улсын бүртгэгчид заавар зөвлөмжийг өгч ажилласан.

2019 онд Хэлтсийн даргын батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг Баян-Уул, Баянтүмэн, Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Булган, Гурванзагал, Чулуунхороот сумын улсын бүртгэгч нарын 414 бүртгэлийн үйл ажиллагаа,

бүртгэлийн дэвтэр, бүрдүүлбэр, нотлох баримтыг онлайн санд шалгаж 8 зөрчлийг илрүүлэн 1 улсын бүртгэгчид Хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн ажилласан байна.

Мөн 57 гадаад паспортыг мэдээллийн санд хүчингүй болгож, үүнээс гадаад паспорт гэмтээсэн 1 иргэнд хялбаршуулсан журмаар шийтгэлийн арга хэмжээ оногдуулсан байна.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 31 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч тухайн шатанд шийдвэрлэн ажилласан.



Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийг иргэнд 3ШШ-2 үйлдэж нийт шийтгэлийн хуудсаар 161 иргэнд 3 744000 төгрөгийг торгуулийн арга хэмжээ авсан байна.



➤ ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:


Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 7507 бүртгэл хийгдсэнээс анхан шатны нэгжийн бүртгэл гэр бүлийн байдлын бүртгэл, иргэний үнэмлэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлүүд 4076 буюу 54.3%, үндэсний энгийн гадаад паспорт олголт, ОХУ, БНХАУ-ын хил зорчих үнэмлэх 2040 буюу 27.2%, хууль хяналтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагад лавлагаа 201 буюу 2.7%, иргэнд 1190 буюу 15.8% лавлагаа олгож ажилласан байна.

Мөн дээрх бүртгэлүүдийг улсын бүртгэгч онлайн сүлжээнд шивж, баталгаажуулан, ИУБ маягтыг галиглан Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлийн архивт хүргүүлэн ажиллаж, цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжуулалтыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хэрлэн сумын 10 дугаар багийг өөрчилж 11 дүгээр баг шинээр байгуулах тухай” тогтоолын хүрээнд 11 дүгээр багийн 2684 иргэний мэдээллийг хаягийн сантай тулгалт хийж шалгаж шилжилт хөдөлгөөний бүртгэл хийхэд бэлэн болгосон.

2018, 2019 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэлийг харьцуулбал:





➤ ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэд, хуулийн этгээдээс дээрхи хугацаанд нийт **3303** мэдүүлгийг **ePRS, ePRS 2, eprsland** цахим програмаар хүлээн авч хянан бүртгэсэн байна. Үүнд:

- Төрөөс үнэ төлбөргүй хувьчлагдсан газар өмчлөх эрхийн улсын бүртгэл- **313**
- Газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл- **194**
- Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт- **9**
- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэн баталгаажуулалт- **79**
- Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгэж баталгаажуулах- **47**
- Өмчлөх эрх шилжих гэрээгээр- **536**
- Барьцааны гэрээгээр- **991**
- Барьцааны гэрээ дуусгавар болгох- **673**
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаархи лавлагаа, хуулбар- **364**
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- **89**
- Урьдчилсан тэмдэглэл - **5**
- Хаасан хувийн хэрэг - **3**

бүртгэлийг бүртгэсэн байх ба архивт шинээр **642** ширхэг хувийн хэрэг нээж оруулсан байна. Хагас жилийн байдлаар нийт бүртгэсэн бүртгэлийн **15.3** хувийг газар өмчлөх болон газар эзэмших эрхийн бүртгэл, **4.0** хувийг газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл бүртгэл, **50.3** хувийг барьцааны гэрээ, **16.2** хувийг өмчлөх эрх шилжих гэрээ, **11.0** хувийг лавлагаа хуулбар, **2.9** хувийг гэрээ хэлцлээс бусад эрхийн улсын бүртгэл эзэлж байна.

Хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагаас ирсэн нийт 116 албан бичгийг хүлээн авч эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой хариу тайлбар, лавлагааг албан бичгээр хүргүүлсэн байна.

Мөн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн сар бүрийн нэгдсэн мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв гарган Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар болон холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн байна.

➤ **АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР**

Архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэх, архивын сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, нууцлал, нөхөн бүрдүүлэлт, мэдээ тайлан гаргах, шаардлагатай мэдээллийг удирдлагад танилцуулах, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, иргэний бүртгэлтэй холбоотой эрхлэн хөтөлсөн бүртгэлийн баримтаар архивын санг бүрдүүлэх, цахим архивын сан үүсгэх, чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт нийт 36051 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс: Газар -25081, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө-10967, хөдлөх хөрөнгө-3.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны явцад бий болсон 3303 мэдүүлэг нотлох баримтыг цахимжуулж, мэдүүлэг хүлээлцэх маягын дагуу улсын бүртгэгчээс хүлээн авч, шинээр үүсгэсэн газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 135, газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн 507 хувийн хэрэг архивт Маягт А-1-ийн дагуу хүлээн авч, байршуулан ажиллаж байна.

Архивын мэдээ тайлан мэдээг цаг тухай бүрт нь гарган холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн архив

Тайлант хугацаанд нийт 4076 иргэний бүртгэлийн маягтуудыг архивт хүлээн авч байршуулсан бөгөөд 124 иргэний хувийн хэргийг шилжин явсан харъяа газарт нь хүргүүлэн ажилласан.

Иргэний бүртгэлийн архивт эмхлэх, цэгцлэх ажлыг шат дараатай хийж гүйцэтгэж байгаа бөгөөд тайлант хугацаанд хувийн хэргийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг хангах, сайжруулах зорилгоор хувийн хэргүүдийг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглаж 1020 ширхэг бор хайрцагт нийт 35700 иргэний хувийн хэргийг байршуулж хадгаламжийн санг үүсгээд байна.



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 2173 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Тайлант хугацаанд шинээр 91 аж ахуй нэгж, татан буугдсан 9, шилжин явсан 5, шилжин ирсэн 4, нэмэлт өөрчлөлтийн 285 хувийн хэргийг УБЕГ-ын даргын 2015 оны 335 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралтын дагуу бүртгэл хөтлөн хүлээн авч, улсын бүртгэгчид хүлээлгэн өгч ажилласан.

Хуулийн этгээдийн 2068 хувийн хэргийг 100 хувь цахимжуулсан.

Хуулийн этгээд улсын бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэлийн архивын тоон мэдээг сар бүрийн 25-ны өдрийн дотор гаргаж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын газарт хүргүүлэн ажилласан.

Архивын өрөө тасалгааны аюулгүй байдал, хадгаламжийн нэгжийн бүрэн, бүтэн байдал болон стандартыг баримтлан ажиллаж байна.

➤ **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын 2068 хувийн хэргийг 2018 оны 11 дүгээр сарын 01-наас 2019 оны 02 дугаар сарын 28-ны хүртэлхи хугацаанд бүрэн цахимжуулж дуусгасан байна. Үүнд:

- ТБАГ-149
- ОНӨААТҮГ-15
- ТӨХК-1
- ХК-9
- ХХК-1424
- ББСБ-7
- АУДИТ-1
- ХЗХ-7
- ХОРШОО-77
- БГБХН-47
- ЗГБХН-26
- ХХН-2
- НҮТББ-163
- ГҮТББ-52
- БСБ-10
- ҮЭ-53
- ХМБ-5
- САН-12
- ШАШИН-8

Тайлант хугацаанд 90 аж ахуйн нэгж, байгууллага шинэчилэн, шилжин ирүүлсэн, шинээр үүсгэн байгуулагдан үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөл авч, хуульд заасан хугацаанд холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн тул улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ гардуулан өглөө.

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Тайлант хугацаанд 104 нэр төрлийн нэмэлт өөрчлөлт оруулж, 77 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив мэдээллийн хадгаламжийн сангаас лавлагаа /тодорхойлолт/ гарган, шинэчилсэн болон үрэгдүүлсэн, гэмтээсэн /шилжиж ирсэн/ шалтгаанаар 20 аж ахуйн нэгж, байгууллагад дахин гэрчилгээг тус тус олгосон болно.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаа явуулах явцад Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу 6.386.000 мян.төгрөгийн хураамжийг орон нутгийн төсвийн дансанд оруулав. Үүний 46.0 мян.төгрөгийн хураамжийг иргэн, хуулийн этгээдэд шинээр оноосон нэр олгож баталгаажуулж улсын төсвийн дансанд оруулав.

Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, гэмтээсэн, оноосон нэр, хэлбэр өөрчилсөн үрэгдүүлсэн гэх мэт үндэслэлээр 104 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тамганы хяналтын дугаар олгох үйлчилгээ үзүүлсэн байна.

Аймгийн Татварын хэлтсийн татварын байгцаагч болон хяналт шалгалтын тасгийн байцаагч нараар шалгагдаж өр төлбөрөө бүрэн барагдуулан холбогдох баримт материалаа бүрдүүлж татан буугдахаар хүсэлт гаргасан 9 аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасч татан буулган, хувийн хэргийг архивлан архивт шилжүүлэхэд бэлэн болгоод байна. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хэлбэр регистр, оноосон нэр өөрчилсөн, татан буугдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 19 тамгыг хураан авсан байна.

НАЙМ.САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тус хэлтэс нь 2019 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын газарт хүргүүлэн санхүүгийн аудит хийлгэж, Төрийн аудитын газраас 2019.02.25-ны өдрийн 125 тоот албан бичгээр “Зөрчилгүй” санал дүгнэлт бүхий аудитын гэрчилгээг олгосон.

Тайлант хугацаанд 155776,9 төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж 152945,1 төгрөгийн буюу 98.2% төсвийн гүйцэтгэлтэй, 2831,7 төгрөгийн буюу 1.8%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулах, төсвийн зардлыг бууруулах ажлын хүрээнд “МХС” ТӨК-тэй байгуулсан №До/LC/19/01-26 тоот сувагчлалын түрээсийн гэрээгээр шилэн шөрмөсийн сарын төлбөрийг 93,5 төгрөг болгон сар бүр шуудан холбооны зардалд 11,0 төгрөгийн бодит хэмнэлттэй ажиллаж байна.

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд шивж, www.shilendans.gov.mn, байгууллагын www.ubh.dd.gov.mn сайт болон мэдээллийн самбарт 64 мэдээллийг байршуулсан биелэлт 100%-тай байна.

ЕС. БУСАД

❖ УБЕГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 2/534 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, зөвлөмж, хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комиссын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 02 тоот хурлын тэмдэглэл үндэслэн устгал хийх ажлын хэсгийг байгуулан хадгалах хугацааны жагсаалт дахь хадгалах хугацаа дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, хувийн хэргийн баримттай давхардсан цаашид архивд хадгалах шаардлагагүй болсон 10650 хуудас бүхий баримт бичгийг устгасан.



Жил бүрийн 3 дугаар сарын эхний долоо хоногт “Музейн нээлттэй өдрүүд”-ийг зохион байгуулах болсонтой холбогдуудан Монгол ахуй, өв соёлыг өвлүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор хэлтсийн албан хаагчдийн хүүхдүүдэд музей үзүүлсэн.



2019 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Дорнод аймгийн Хөгжимт драмын театрт тоглогдсон “Бардам туулай” жүжгийг хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдэд үзүүлэв.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Жаргалтай үрс” баярын арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг өгч хүүхдүүдийн дунд 3-6 нас, 7-9 нас, 10-12 насны ангилалд “Миний ертөнц-Миний бүтээл” гар зургийн уралдаан зарлаж эхний 2 байрыг тус тус шалгаруулж өргөмжлөл, дурсгалын зүйл хадгалуулав. Мөн азтан тодруулж, хүүхдүүд өөрийн авьяасаа үзүүлж гарын бэлэг гардан авлаа.



АРАВ. ДҮГНЭЛТ

Тус хэлтэс нь 2019 оныг “ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ” болгон зарласан бөгөөд энэхүү зорилтот жилийн хүрээнд Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг хэрэгжүүлж, иргэдэд бүртгэлийн үйлчилгээний шат, дамжлагыг бууруулах, түргэн шуурхай үйлчлэх чиглэлээр:

- УГТАХ, ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ
- ИРГЭН ТАНЫ ГЭРТ, ГАРТ ҮЙЛЧИЛГЭЭ
- МЕССЕЖ ҮЙЛЧИЛГЭЭ
- ОНЛАЙН ХАЙЛТЫН СИСТЕМ зэрэг олон шинэлэг арга хэмжээг

хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд дээрх үйлчилгээнүүд нь олны талархалыг хүлээсэн ажил болоод байна.

Мөн цаашид иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлд илүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ОЮУНБАЯР

АГУУЛГА

НЭГ. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА:

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГАА:

ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦ.

ДӨРӨВ. ИЛ ТОД БАЙДАЛ

- Цахим мэдээ, мэдээллийн ил тод байдал
- Бүртгэлийн үйлчилгээний ил тод байдал

ТАВ. СУРГАЛТ

- Иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн сургалт
- Албан хаагчдад чиглэсэн сургалт

ЗУРГАА. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

ДОЛОО. БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Бүртгэл хяналтын чиглэлээр
- Иргэний улсын бүртгэл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл

НАЙМ. САНХҮҮ

ЕС. БУСАД

АРАВ. ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2019 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 04 дүгээр
сарын 26 -ны өдөр

Чойбалсан хот

НЭГ.ОРОН НУТАГТ УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР ХҮНДИЙГ
ӨНДӨРТ ӨРГӨЖ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАА УХАМСАРЛАХ АЖЛЫН
ХҮРЭЭНД

❖ Тус хэлтэс нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан бодлогын бичгүүдийг танилцуулах нээлтийн арга хэмжээний хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг Цагдаагийн газартай хамтран идэвхи санаачлагатай, үр дүнтэй зохион байгуулсныг үнэлэн аймгийн Цагдаагийн газраас “Талархал” гардуулав.



❖ Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчилан таниулах зорилго бүхий “АРХИГҮЙ ДОРНОДЫН ТӨЛӨӨ” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “АРХИГҮЙ АМЬДРАЛЫГ БИД ХҮСНЭ” АСК тэмцээнд амжилттай оролцов.



❖ 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “ЗӨРЧИЛГҮЙ” дүгнэлт авсан.



❖ Жил бүрийн 3 сарын сүүлийн долоо хоногийн пүрэв гаригт 16 цагаас зохион байгуулагддаг онцгой бэлэн байдлын дуут дохиот дадлага сургалтанд тус хэлтэс хамрагдаж, дадлага сургуулилтыг гүйцэтгэв.



❖ Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ахмадаа “Сар шинийн баяр”-ыг угтаж үндэсний үйлдвэрийн сүү, сүүн бүтээгдэхүүнээр бэлэг барив.



ХОЁР.ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД

2019 онд хийж хэрэгжүүлэх ажил, үүрэгтэй холбоотойгоор аймгийн Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан нийт 28 арга хэмжээ, тусгайлан сонгосон 28 арга хэмжээний биелэлтийг ханган ажиллаж байна.



Мөн төрийн байгууллага, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах төлөвлөгөө, тулгамдаж буй асуудлаар Аймгийн ЗДТГ-ын 2019 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн шуурхай хуралдаанд мэдээлэл хийж ажилласан. Тус хэлтэс нь Аймгийн Засаг даргын тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн дэх газар, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүүхэд гэр, бүл хөгжлийн газар зэрэг байгууллагуудтай өдөр тутмын үйл ажиллагаагаар хамтран ажиллаж байна.



❖ Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Булган, Баяндун, Хөлөнбуйр, Сэргэлэн, Матад, Гурванзагал, Чойбалсан, Баянтүмэн сумдыг онлайн сүлжээнд холбох ажлыг шийдвэрлүүлээд байна.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

- ❖ Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл”-ийн гишүүд тус хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцов.




- ❖ Хууль хяналтын байгууллагад хуулийн хүрээнд тайлант хугацаанд албан бичгээр 230 лавлагаа олгож ажилласан.
- ❖ Тайлант хугацаанд аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт шинээр төрсөн 465 хүүхэд, нас барсан 122 иргэн, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нас барсан 122 иргэн, Хүүхэд гэр, бүл хөгжлийн газарт 10 хүүхдийн үрчлэлтийн судалгаа, мэдээллийг тус тус гарган сар бүрийн 25-нд хүргүүлж хамтран ажиллаж байна.

ГУРАВ.ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 08 сарын 24-ны өдрийн Б/89 тушаалаар хэлтсийн бүтэц, орон тоо батлагдаж төрийн захиргааны албан хаагч -25, төрийн үйлчилгээний ажилтан -4, гэрээт -2 нийт 31 албан хаагчтайгаар аймгийн 80 мянга гаруй иргэнд төрийн бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.



❖ Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, Монгол улсын “Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ” 2005:5538 стандарт, “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих”, “Биеийн тамир, спортыг бүх нийтийн хэрэглээ болгоцгооё” жилийн хүрээнд “Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-д байгууллагын албан хаагчдаа бүрэн хамруулж, сорилын 9 төрлөөр өөрсдийн бие бялдрын түвшинг тодорхойлж, үнэлгээгээ тогтоолоо.



❖ Аймгийн Биеийн тамир, спортын газраас төрийн албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан “Хамт олноороо бадминтон тоглоцгооё” өдөрлөгт амжилттай оролцсон.



❖ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол Цэргийн өдрийг тохиолдуулан албан хаагчдаа баярлуулав.




- Хүний нөөцийн ажлын хэсэг ажилласан жилийн, шагналын, орон сууцны, хүүхдийн, албан тушаал сэлгэн ажиллах, ажлын байр өөрчлөх, Мэргэжил дээшлүүлэх болон сурч боловсрох зэрэг судалгаануудыг шинэчлэн авч сан үүсгэн ажилласан.
- Итгэл Ивээлт эмнэлэгтэй хамтран албан хаагчдыг урьдчилан сэргийлэх ЭХО аппарат болон зүрхний цахилгаан бичлэг хийлгүүлэхээр болсон бөгөөд үзлэгийн төлбөрийн асуудал шийдвэрлэлтийн шатандаа явагдаж байна.
- Албан хаагчдын 2-12 насны 29 хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг шүдний СУПЕРДЕНТ эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан.
- Чойбалсан сумын улсын бүртгэгчийн түр орон тоо, Цагаан-овоо сумын улсын бүртгэгчийн сул орон тооны мэдээллийг байгууллагын ubh.dd.gov.mn цахим сайт, Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн фэйсбүүк хуудсанд тухай бүр байршуулж ажилласан.
- Ажилд орохыг хүссэн 4 иргэнээс материал хүлээн авч мэдээллийн санд бүртгэн, төрийн албаны шаардлага хангасан 1 иргэний материалыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтэст хүргүүлж ажилласан.
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 30 албан хаагчдийн хувийн хэргийг шинэчлэн баяжилтыг хийж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Захиргаа, хүний нөөцийн хэлтэс хэлтсийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 343 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Албан хаагчдын ажил үүргийн давхардалыг арилгах зорилгоор хэлтсийн даргын тушаалаар 12 ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Үүнд:
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл
 - Авлигын эсрэг орон тооны бус зөвлөл
 - Жендерийн эрх тэгш байдлыг хангах орон тооны бус зөвлөл
 - Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөл
 - Терроризмоос урьдчилан сэргийлэх ажлын хэсэг
 - Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг
 - Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний баг
 - “Ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийг хангах ажлын хэсэг
 - Биеийн тамир спорт, эрүүл мэндийг дэмжих ажлын хэсэг
 - Сургалт хариуцсан ажлын хэсэг
 - Баримт бичиг нягтлан шалгах комисс
 - Эцэг, эхийн зөвлөл зэрэг ажлын хэсгүүдийг байгуулсан.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР


ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 9/2107 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын www.ubh.dd.gov.mn цахим сайтыг “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах заавар чиглэл”-ийн дагуу шинэчилж ажилласан.



Үүнд: Байгууллагын цахим сайтыг 7 үндсэн цэс 40 дэд цэс болгож шинэчилсэн.

8. Эхлэл



9. Бидний тухай

- 9.1. Мэндчилгээ
- 9.2. Танилцуулга
- 9.3. Түүхэн замнал
- 9.4. Зорилго, зорилт
- 9.5. Тэргүүлэх чиглэл
- 9.6. Стратегийн зорилт
- 9.7. Тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл

10. Мэдээ, мэдээлэл
 - 3.1. Видео мэдээ
 - 3.2. Сумдууд /14 сум орсон /
11. Бүртгэлийн үйлчилгээ /бичиг баримтын бүрдүүлэлт, үнэ хураамжийн талаарх мэдээлэл/
 - 11.1. Иргэний бүртгэл
 - 11.2. Эд хөрөнгийн эрхийн бүртгэл
 - 4.3. Хуулийн этгээдийн бүртгэл
12. Хууль тогтоомж
 - 12.1. Улсын бүртгэлийн багц хуулиуд
 - 12.2. Хууль зүйн сайдын тушаал
 - 12.3. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол
 - 12.4. Бүртгэл хөтлөх журам
 - 12.5. Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бусад хуулиуд
 - 12.6. УБЕГ-ын даргын тушаал
 - 12.7. Хэлтсийн даргын тушаал
 - 12.8. Нийтлэг дүрэм, журам
13. Байгууллагын ил тод байдал
 - 13.1. Өргөдөл, гомдол хүлээн авах
 - 13.2. Хэлтсийн даргын иргэдийг хүлээн авах цагийн хуваарь
 - 13.3. Хүний нөөцийн ил тод байдал
 - 13.4. Санхүүгийн ил тод байдал
 - 13.5. Шилэн данс
 - 13.6. Статистик тоон мэдээ
14. Үйлчлүүлэгч таньд
 - 14.1. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ
 - 14.2. Байгууллагын үйлчилгээний стандарт
 - 14.3. Статистик тоо мэдээ
 - 14.4. Төлөвлөгөө
 - 14.5. Тайлан
 - 14.6. Хүчингүй бичиг баримт
 - 14.7. Түгээмэл асуулт хариулт

Байгууллагын цахим сайт www.ubh.dd.gov.mn болон Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк www.facebook.com/ubh.dornod группээрээ дамжуулан олон нийтэд мэдээ, мэдээллийг тогтмол түгээн сурталчлан ажиллаж хэвшээд байгаа бөгөөд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар цаг үе, үйл явдалтай холбоотойгоор 33, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах чиглэлээр цахим хуудсаар хууль сурталчлах 51 баннер, зурагт мэдээлэл байршуулж, цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 40 иргэнд зохих мэдээлэл, тайлбарыг хүргэж ажилласан ба өнөөдрийн байдлаар 630922 хандалт хийгдсэн байна.



Мөн WWW.facebook.com/UBh.dornod/ хуудсанд “Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс” мэдээлэл сурталчилгааг иргэдэд хүргэн ажиллаж байна. Одоогийн байдлаар **2377** дэмжигчидтэй байна.

БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

Тус хэлтэс нь 2019 оныг **“ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ”** –ний жил болгон зарласан бөгөөд зорилтот жилийн хүрээнд 18 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

БАТЛАВ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

3369887 2116129095



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН “ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ”
ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.03.13 Хэрлэн сум

Зорилго. МУ-ын ЗГ-аас “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жил болгон зарласантай холбогдуулж, тус хэлтэс зорилтоо ийнхүү дэвшүүлсэн бөгөөд Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг нэвтрүүлэх, УБЕГ-аас бүртгэлийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр барьж буй бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, иргэн-үйлчлүүлэгч бүртгэлийн хууль тогтоомж, үйлчилгээний талаарх мэдээллийг өөрт хамгийн ойр эх сурвалжаар тогтмол авч мэдлэгээ дээшлүүлэх, цахим хэлбэрээр үзүүлж болох үйлчилгээ, боломжийг нэмэгдүүлж, иргэдээс гарах зардал чирэгдлийг бууруулах, цаг хугацааг хэмнэхэд чиглэгдэнэ.

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ	ХУГАЦАА	ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН	ХҮРЭХ ҮР ДҮН
НЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР				
1.	УБЕГ-аас “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд аймгийн 8 сумыг иргэний бүртгэлийн онлайн сүлжээнд холбох	Жилдээ	Хэлтсийн дарга Д.Оюунбаяр	Иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бүртгэлийн үйлчилгээг авах боломжтой болсон байна.
2.	Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биеэр ирж үйлчлүүлэх боломжгүй иргэдийн цахимаар ирүүлсэн хүсэлтийн дагуу “Иргэн таны гэрт, гэрт” гэрээр үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх.	3 сарын 15-ны өдрөөс эхлэн цаашид тогтмол	Улсын бүртгэгч М.Галбадрах Улсын бүртгэгч П.Шижирбаатар	Дээрх хүндэтгэн үзэх шалтгаантай иргэд бүртгэлийн үйлчилгээг ямар нэгэн зардал гаргахгүй, цаг алдалгүй гэрээр авах боломж бүрдсэн байна.
3.	Хэлтсийн вэб сайтын “Онлайн лавлагааны систем” булангийн үйл ажиллагааг сайжруулах, үндэсний энгийн гадаад паспорт, иргэний үнэмлэх, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, газрын гэрчилгээ зэрэг баримт бичгийн хэвлэлтийн талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэх.	Тухай бүр	Улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг Улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг	Орон зай, цаг хугацаанаас үл хамааран иргэд онлайн сүлжээгээр өөрийн регистрийн дугаарыг ашиглаж захиалсан гэрчилгээ, иргэний цахим үнэмлэх, гадаад паспорт хэвлэгдсэн эсэх талаар мэдээлэл авах боломжтой болсон байна.
4.	16, 25, 45 насны иргэдийн судалгааг үндэслэн багийн ажлын албатай хамтран иргэний үнэмлэх шинээр захиалах болон сунгалтын мэдээлэл	Сөр бүр	13 сумын улсын бүртгэгчид	Тухайн иргэд энэ талаарх мэдлэггүйгээсээ шалтгаалж өөрсдөө хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсооно.


❖ Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлж буй иргэн бүрийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, үйлчилгээний соёл, сэтгэл ханамжийн баталгааг өндөржүүлж, харилцааны болон үйлчилгээний зөрчилгүй хамт олон болох зорилгоор **“УГТАХ, ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 464 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч чиглүүлэн ажиллаж байна.



❖ Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг хэрэгжүүлж, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх зорилгоор **“ИРГЭН ТАНЫ ГЭРТ, ГАРТ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г нэвтрүүлэн ажиллуулж байна. Энэхүү үйлчилгээгээр өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гадаад паспорт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, цахим иргэний үнэмлэх, лавлагаа зэргийг гэрт нь хүргэн өгдөг бөгөөд тайлант хугацаанд 21 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.



❖ Интернет орчинд байдаг үйлчлүүлэгч иргэд **“ОНЛАЙН ЛАВЛАГААНЫ СИСТЕМ”**-ийг ашиглан гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ зэргээ хэвлэгдэн ирсэн эсэхийг заавал ажлын байранд ирэх шаардлагагүйгээр регистрийн дугаараараа шалгах боломжтой бөгөөд тайлант хугацаанд 350 иргэний мэдээллийг оруулсан байна.



❖ Иргэдийн хэвлэгдэн ирсэн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэхийг “**МЕССЕЖ ҮЙЛЧИЛГЭЭ**”-ээр мэдээллийг хүргэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 280 иргэд мессеж мэдээллийг хүргэн ажилласан байна.



❖ Иргэд байгууллагын “**НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970**” дугаарт холбогдон бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах боломжтой бөгөөд тайлант хугацаанд 187 иргэн үйлчлүүлсэн байна.



❖ Байгууллагын WWW.UBH.DD.GOV.MN цахим сайтаар дамжуулан байгууллагын бүртгэлийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах зорилгоор мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.



❖ “ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС” Facebook /ubh.dornod/ хуудсаар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэхээс гадна онлайн чатаар иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд 40 иргэний сонирхсон асуултанд хариулж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



❖ Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор Голомт банктай хамтран “**ПОС ТЕРМИНАЛ**” машин ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 270 иргэнд үйлчилсэн.



❖ Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор мэдүүлэг хүлээн авах цонхонд үйлчилгээний дансны дугаар болон улсын бүртгэгч нарын ажил үүргийн хуваарийг шинэчлэн ажиллаж байна.



❖ Байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын самбарт мэдээллийг тогтмол болон байнга шинэчлэх зориулалттай ухаалаг самбарыг байршуулан ажиллаж байна.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР:

Орон нутгийн хэвлэл мэдээллийн томоохон нэгж болох Мижи ТВ-тэй байгуулсан гэрээний дагуу шинэ хуулийн талаар сурталчилгаа мэдээллийг 10 удаагийн давтамжтай, нийт 60 реклам сурталчилгааг нэвтрүүлж хамтран ажилласан байна. Мөн түүнчлэн “D” телевизд “Цахим иргэний үнэмлэх болон шилжилт хөдөлгөөний бүртгэл”-ийн талаархи шинэ хуулинд гарсан өөрчлөлт, бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой заалтын талаар 3 удаа зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

ТАВ.СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР НЭГ. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЧИГЛЭСЭН ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн багц хууль, шинээр нэвтэрсэн үйлчилгээ, тус хэлтсээс 2019 онд дэвшүүлсэн “Иргэнд ойр бүртгэлийн цахим үйлчилгээний жил” зорилтот жилийн ажлын талаар нийт 6060 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэж, дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

а/ Аймгийн нийгмийн асуудал хариуцсан төрийн байгууллагуудын хамтарсан сургалтын баг бүрэлдэхүүнд багтаж, Хэрлэн сумын 10 багуудад 4 удаагийн сургалтаар нийт 500 гаруй иргэдийг хамруулж, мэдээлэл хүргэж, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгч ажилласан.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

б/ Дээрх сургалтыг сумдад үе шаттайгаар зохион байгуулж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд Чойбалсан, Гурванзагал, Баянтүмэн сумдын нийт 760 гаруй иргэдэд мэдээлэл хүргэж, сонирхсон асуултанд хариулт өгөв.



в/ Хэрлэн сумын ЗДТГ мэдээлэл хүргэж, сонирхсон асуултанд хариулт өгч ажилласан. Сургалтанд нийт 45 албан хаагч хамрагдсан.



г/ Хууль зүйн яамны харъяа агентлагуудын нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож мэдээлэл хүргэж, 21 иргэний сонирхсон асуултанд хариулт өгөв.



д/ Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Хэрэглэгчээ сонсоё” нээлттэй хаалганы өдөрлөгт тус хэлтэс оролцож, нийт 25 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажилласан.



е/ 2019 оны 01 дүгээр сарын 28-ны аймгийн Удирдах ажилтны шуурхай хуралдаанд Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулгаар мэдээлэл хийж, сонирхсон асуултанд хариулав. 70 албан хаагч хамрагдсан.



ё/ 2019 оны 01 дүгээр 29-ны өдөр БОЭТөвийн ажилчин албан хаагчдад Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулгаар мэдээлэл хийж, сонирхсон асуултанд хариулав. 43 албан хаагч хамрагдсан.



ж/ 2019.03.26-ны өдөр Хэрлэн сумын багийн Засаг дарга болон нийгмийн ажилтан нарт Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулгаар мэдээлэл хийж, тус байгууллагуудын албан хаагчдын асуултад хариулт өгч ажилласан. Сургалтанд 20 албан хаагч хамрагдсан.



з/ Тус аймгийн 14 сумын улсын бүртгэгч сумынхаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдэд Улсын бүртгэлийн багц хууль, шинээр нэвтэрч буй үйлчилгээний талаар нийт 4576 иргэнд зөвлөгөө, мэдээллийг хүргэж ажилласан.



ХОЁР. АЛБАН ХААГЧДАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тус хэлтэс нь өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 16 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 104 албан хаагч хамрагдахаас 100 албан хаагч хамрагдсан. Ирц 96 хувьтай. Үүнд:

а/ Дорнод аймгийн төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн “Хандлага-Өөрчлөлт” нэртэйгээр зохион байгуулагдаж, тус хэлтсээс дарга Д.Оюунбаяр, улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг, улсын бүртгэгч Ц.Энхмаа нар хамрагдаж,

төрийн албан хаагчдын хандлага, хариуцлагын чиглэлээр 2 өдрийн лекц сургалтанд хамрагдсан.



б/ Алба хаагчдын суралцах арга барилыг сайжруулах чиглэлээр Mind Up сургалтын төвөөс зохион байгуулж буй “Суралцах ур чадвар” сэдэвт сургалтанд хэлтсийн нийт алба хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.



в/ Аймгийн Прокурорын газраас “Албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт авч, хэлтсийн 11 албан хаагчийг хамруулсан.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

г/ Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг “Авилга, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр бие даан судалж, алба хаагчдад сургалт зохион байгуулав. Сургалтанд 8 албан хаагч хамрагдсан.



д/ Аймгийн Замын цагдаагийн газраас замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, хэлтсийн алба хаагчид бүрэн хамрагдав.



е/ Аймгийн Татварын хэлтсээс Татварын шинэчилсэн хууль тогтоомж, цахимаар төлбөрийн даалгавар, нэхэмжлэх үүсгэх чиглэлээр сургалт зохион байгуулж, хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдав.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

ё/ Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бөгөөд тус зөвлөгөөнд хяналтын улсын байцаагч Л.Сугаррагчаа хамрагдаж, мэргэжлийн ур чадвараа сайжруулсан.



ж/ Дорнодын залуус ТББ-аас зохион байгуулсан Манлайлагч залуусын сургалтанд хэлтсийн Бичиг хэргийн эрхлэгч Т.Сэржмаа, архивч С.Батчимэг нар хамрагдав.



з/ Аймгийн ЗДТГ, Дорнод их сургуулиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-нд улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг, улсын бүртгэгч Ц.Энхмаа нар хамрагдав.



ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС


и/ Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс зохион байгуулсан нийгмийн даатгалын чиглэлээр шинээр нэвтрүүлсэн үйлчилгээ “Нийгмийн даатгал” аппликэйшнийг танилцуулах сургалтанд хэлтсийн төвийн алба хаагчид бүрэн хамрагдсан.

й/ Аймгийн ЗДТГ, Дорнод их сургуулиас зохион байгуулсан Төрийн алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хүрээнд Хүний нөөцийн асуудал хариуцсан алба хаагчдад зориулсан сургалтанд архивч С.Батчимэг хамрагдаж, мэргэжлийн ур чадвараа сайжруулсан.



к/ Аймгийн ХГБХГ-аас зохион байгуулсан “Багийн хамтын ажиллагаа, харилцаа холбоо” сэдэвт сургалтанд ЭХЭУБТ-ийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ж.Ганзориг хамрагдсан.

л/ УБЕГ-ын даргын 2019 оны Б/43 тоот тушаалаар ЭХЭУБТ-ийн улсын бүртгэгчээр томилогдсон Н.Гантуяад ажлын байран дахь сургалтыг зохион байгуулсан.



Мөн түүнчлэн УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалтанд Хяналтын улсын байцаагч Л.Сугаррагчаа 2, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Болор-Эрдэнэ 1 удаа тус тус хамрагдсан.

ЗУРГАА.ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан 288 санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч тухай бүрт нь шийдвэрлэж хариу өгч ажилласан. Дээрх санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг ангилвал:

- Нээлттэй утас 98970970 дугаарт -187
- Санал хүсэлтийн дэвтэрт -13
- Санал хүсэлтийн хайрцагт -4
- Биечлэн хандсан -49
- Бичгээр -32
- ЗДТГ-ын 70582233 Нээлттэй утсанд -2
- Хэлтсийн цахим хаягаар -1

Байгууллагад ирсэн 288 санал, хүсэлт, өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж үзвэл гомдол -6 буюу 2%, талархал-14 буюу 5%, санал, хүсэлт, өргөдөл-268 буюу 93%-ийг эзлэж байна.

➤ Байгууллагын Нээлттэй утас 98-970-970 дугаарт 187 иргэн хандсан ба үүнд: иргэний улсын бүртгэлтэй холбоотой 164 буюу 87,7%, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 17 буюу 9.09%, Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 6 буюу 3.21 % зөвлөгөө, мэдээллийг иргэнд хүргэж ажилласан байна.

➤ Аймгийн ЗДТГ-ын “Нээлттэй утас” 7058-2233 дугаарт 2 иргэн хандаж өргөдөл, гомдол гаргаснаас иргэний бүртгэлтэй холбоотой 1 буюу 50%, албан хаагчдтай холбоотой 1 буюу 50%-ийг тус тус эзэлж байна.

➤ Санал хүсэлтийн дэвтэрт 13 иргэн санал, хүсэлт, гомдлоо илэрхийлснээс талархал 12 буюу 92.3 %, гомдол- 1 буюу 7.7% тус тус эзэлж байна.


➤ Санал хүсэлт хүлээн авах хайрцагт 4 иргэн санал, хүсэлт, гомдлоо илэрхийлснээс талархал 2 буюу 50.0 %, гомдол 2 буюу 50.0 % эзэлж байна.

➤ Бичгээр гаргасан 32 өргөдлийг ангилбал: Чөлөө хүсэх тухай 1 буюу 3.13%, албан хаагчтай холбоотой 1 буюу 3,13 %, бүртгэлийн зөрчилтэй холбоотой 16 буюу 50%, гадаад паспортын талаар 2 буюу 6.25%, улсын бүртгэгчтэй холбоотой 1 буюу 3,13%, тэмдэгтийн хураамжийн буцаалт 4 буюу 12.5%, төрсөн эх нас барсан тухай тэтгэмж 1 буюу 3.13%, сумын улсын бүртгэгч ажилд авах тухай 2 буюу 6.25%, ажилласан жилийн лавлагаа авах тухай 2 буюу 6.25%, хүний нөөцтэй холбоотой 2 буюу 6.25% тус тус эзэлж байна.

ДОЛОО.БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

➤ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:


Хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 2213 бүртгэлийг хянаж шалгаснаас Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 1533 буюу 69.2%, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 350 буюу 15.8%, Хуулийн этгээдийн улсын бүртгэл 120 буюу 5.4%, 150 архив буюу 6.7 % бүртгэлүүдийг архивын хувийн хэрэг эх нотлох баримтыг татаж шалгаж ажилласан.



Тайлант хугацаанд Хэрлэн сумын улсын бүртгэгчийн бүртгэлийн үйл ажиллагаа **1153** бүртгэлийн, нотлох баримт бүрдүүлбэрийг бүртгэлийн дэвтэр, онлайн санд шалгаж 9 зөрчлийг илрүүлэн, тухайн шатанд улсын бүртгэгчид заавар зөвлөмжийг өгч ажилласан.

Мөн 45 гадаад паспортыг мэдээллийн санд хүчингүй болгож, үүнээс гадаад паспорт гэмтээсэн 1 иргэнд хялбаршуулсан журмаар шийтгэлийн арга хэмжээ оногдуулсан байна.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 27 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч тухайн шатанд шийдвэрлэн ажилласан.



Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийг иргэнд ЗШШ-2 үйлдэж нийт шийтгэлийн хуудсаар 125 иргэнд 2.990000 төгрөгийг торгуулийн арга хэмжээ авсан байна.


➤ ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:



Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 4044 бүртгэл хийгдсэний 2292 буюу 56.7 хувь нь гэр бүлийн байдлын бүртгэл, иргэний үнэмлэх, шилжилт хөдөлгөөний бүртгэлүүд, 990 буюу 24.5 хувь нь үндэсний энгийн гадаад паспорт олголт, ОХУ, БНХАУ-ын хил зорчих үнэмлэх, 98 буюу 2.4 хувь нь хууль хяналтын байгууллагад лавлагаа, 664 буюу 16.4 хувь нь иргэнд лавлагаа олгож ажилласан байна.

Мөн дээрх бүртгэлүүдийг улсын бүртгэгч онлайн сүлжээнд шивж, баталгаажуулан, галиглан Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлийн архивт хүргүүлэн ажиллаж, цахим мэдээллийн санг эрхлэн хөтөлж тухай бүр баяжуулалтыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хэрлэн сумын 10 дугаар багийг өөрчилж 11 дүгээр баг шинээр байгуулах тухай” тогтоолын хүрээнд 11 дүгээр багийн 2684 иргэний мэдээллийг хаягийн сантай тулгалт хийж шалгаж шилжилт хөдөлгөөний бүртгэл хийхэд бэлэн болгосон.

2018, 2019 оны 2 дугаар улирлын байдлаар бүртгэлийг харьцуулбал:





➤ ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэд, хуулийн этгээдээс тайлант хугацаанд нийт **1718** мэдүүлгийг **ePRS**, **ePRS 2** цахим програмаар хүлээн авч хянан бүртгэсэн байна. Үүнд:

- Төрөөс үнэ төлбөргүй хувьчлагдсан газар өмчлөх эрхийн улсын бүртгэл-141
- Газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл- 80
- Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт- 4
- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэн баталгаажуулалт- 43
- Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгэж баталгаажуулах- 26
- Өмчлөх эрх шилжих гэрээгээр- 258
- Барьцааны гэрээгээр- 444
- Барьцааны гэрээ дуусгавар болгох- 469
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаархи лавлагаа, хуулбар- 203
- Бүртгэлд өөрчлөлт оруулах-44
- Урьдчилсан тэмдэглэл -4
- Хаасан хувийн хэрэг -2

бүртгэлийг бүртгэсэн байх ба архивт шинээр 294 ширхэг хувийн хэрэг нээж оруулсан байна.

1 дүгээр улирлын байдлаар нийт бүртгэсэн бүртгэлийн 12.8 хувийг газар өмчлөх эрх болон газар эзэмших эрхийн бүртгэл, 4.0 хувийг газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл бүртгэл, 53.1 хувийг барьцааны гэрээ, 15.0 хувийг өмчлөх эрх шилжих гэрээ, 11.8 хувийг лавлагаа, 2.9 хувийг гэрээ хэлцлээс бусад эрхийн улсын бүртгэл эзэлж байна.

Хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагаас ирсэн нийт 50 албан бичгийг хүлээн авч эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой хариу тайлбар, лавлагааг 50 албан бичгээр хүргүүлсэн байна.

Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сар бүрийн нэгдсэн мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв гарган Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар болон холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн байна.

➤ **АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЛААР**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив: Тайлант хугацаанд ЭХЭУБ-н архивт Газар - 24856, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө-10905, хөдлөх хөрөнгө-3 нийт 35764 хувийн хэрэг хадгалагдаж байна. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны явцад бий болсон нэмэлт өөрчлөлтийн нотлох баримт, шинээр үүсгэсэн үл хөдлөх хөрөнгийн 262, газрын 431 хувийн хэрэг архивт хүлээн авч МАЯГТ-А1 дэвтрийн дагуу бүртгэж хүлээн авсан.

Иргэний улсын бүртгэлийн архив: Тайлант хугацаанд нийт 1873 иргэний бүртгэлийн маягтуудыг архивт хүлээн авч байршуулсан бөгөөд 112 иргэний хувийн хэргийг шилжин явсан харъяа газарт нь хүргүүлэн ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн архивт эмхлэх, цэгцлэх ажлыг шат дараатай хийж гүйцэтгэсэн. Үүнд:Хувийн хэргийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг хангах, сайжруулах зорилгоор хувийн хэргүүдийг цагаан толгойн үсгийн дарааллаар галиглаж 490 ширхэг бор хайрцагт нийт 17150 иргэний хувийн хэргийг



байршуулж хадгаламжийн санг үүсгээд байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив: Шинээр 53 аж ахуй нэгжийн хувийн хэрэг хүлээн авч хадгаламжийн сан үүсгэсэн. Татан буугдсан 5, нэмэлт өөрчлөлтийн 116 хувийн хэргийг бүртгэлийн дэвтэр хөтлөн хүлээн авч, хүлээлгэн өгч ажилласан.

Хуулийн этгээдийн 2068 хувийн хэргийг цахимжуулалтанд бэлтгэж, бүртгэл хөтлөн, хүлээлгэн өгч, хүлээн авч ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын тоон мэдээг сар бүрийн 25-ны өдөр гаргаж Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын газарт тус тус хүргүүлэн ажилласан.

➤ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын 2068 хувийн хэргийг 2018 оны 11 дүгээр сарын 01-наас 2019 оны 02 дугаар сарын 28-ны хүртэлхи хугацаанд бүрэн цахимжуулж дуусгасан байна. Үүнд:

- ТБАГ-149
- ОНӨААТҮГ-15
- ТӨХК-1
- ХК-9
- ХХК-1424
- ББСБ-7
- АУДИТ-1
- ХЗХ-7
- ХОРШОО-77
- БГБХН-47
- ЗГБХН-26
- ХХН-2

- НҮТББ-163
- ГҮТББ-52
- БСБ-10
- ҮЭ-53
- ХМБ-5
- САН-12
- ШАШИН-8

Тайлант хугацаанд 53 аж ахуйн нэгж, байгууллага шинэчилэн, шилжин ирүүлсэн, шинээр үүсгэн байгуулагдан үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөл авч, хуульд заасан хугацаанд холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн тул улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ гардуулан өглөө. Үүнд: 36 ХХК, 1 ТБАГУТҮГ, 11 ТББ, 3 ҮЭБ, 1 Сан, 1 Хоршоог тус тус бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд 62 нэр төрлийн нэмэлт өөрчлөлт оруулж, 32 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив мэдээллийн хадгаламжийн сангаас лавлагаа /тодорхойлолт/ гарган, шинэчилсэн болон үрэгдүүлсэн, гэмтээсэн /шилжиж ирсэн/ шалтгаанаар 8 аж ахуйн нэгж, байгууллагад дахин гэрчилгээг тус тус олгосон болно.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаа явуулах явцад Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу 3.476.500 мян.төгрөгийн хураамжийг орон нутгийн төсвийн дансанд оруулав. Үүний 26.5 мян.төгрөгийн хураамжийг иргэн хуулийн этгээдэд шинээр оноосон нэр олгож баталгаажуулж улсын төсвийн дансанд оруулав.

Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, гэмтээсэн, оноосон нэр, хэлбэр өөрчилсөн үрэгдүүлсэн гэх мэт үндэслэлээр 57 иргэн аж ахуйн нэгж, байгууллагад тамганы хяналтын дугаар олгох үйлчилгээ үзүүлсэн байна.

Аймгийн татварын хэлтсийн татварын байцаагч болон хяналт шалгалтын тасгийн байцаагч нараар шалгагдаж өр төлбөрөө бүрэн барагдуулан холбогдох баримт материалаа бүрдүүлж татан буугдахаар хүсэлт гаргасан 5 аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасч татан буулган, хувийн хэргийг архивлан архивт шилжүүлэхэд бэлэн болгоод байна. Мөн ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хэлбэр регистр, оноосон нэр өөрчилсөн, татан буугдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын 8 тамгыг хураан авсан байна.

Тайлант хугацаанд 214 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зөвлөгөө өгч, мэдээ мэдээллээр ханган ажиллалаа.

НАЙМ.САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тус хэлтэс нь 2018 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын газарт хүргүүлэн санхүүгийн аудит хийлгэж, Төрийн аудитын газраас 2019.02.25-ны өдрийн 125 тоот албан бичгээр “Зөрчилгүй” санал дүгнэлт бүхий аудитын гэрчилгээг олгосон.

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Тайлант хугацаанд 93.703.8 төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулж 90.868.2 төгрөгийн буюу 96.7% төсвийн гүйцэтгэлтэй, 2.835.0 төгрөгийн буюу 3.3%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсвийн хүрээнд мөнгөн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулах, төсвийн зардлыг бууруулах ажлын хүрээнд “МХС” ТӨК-тэй байгуулсан №До/LC/19/01-26 тоот сувагчлалын түрээсийн гэрээгээр шилэн шөрмөсийн сарын төлбөрийг 98.5 төгрөг болгон сар бүр шуудан холбооны зардалд 42.0 төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна.

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд шивж, www.shilendans.gov.mn, байгууллагын www.ubh.dd.gov.mn сайт болон мэдээллийн самбарт 37 мэдээллийг байршуулсан биелэлт 100%-тай байна.

ЕС. БУСАД

УБЕГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 2/534 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл, зөвлөмж, хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комиссын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 02 тоот хурлын тэмдэглэл үндэслэн устгал хийх ажлын хэсгийг байгуулан хадгалах хугацааны жагсаалт дахь хадгалах хугацаа дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, хувийн хэргийн баримттай давхардсан цаашид архивд хадгалах шаардлагагүй болсон 10650 хуудас бүхий баримт бичгийг устгасан.



АРАВ. ДҮГНЭЛТ

Тус хэлтэс нь 2019 оныг “ИРГЭНД ОЙР БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ” болгон зарласан бөгөөд энэхүү зорилтот жилийн хүрээнд Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг хэрэгжүүлж, иргэдэд бүртгэлийн үйлчилгээний шат, дамжлагыг бууруулах, түргэн шуурхай үйлчлэх чиглэлээр:

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

- УГТАХ, ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ
- ИРГЭН ТАНЫ ГЭРТ, ГАРТ ҮЙЛЧИЛГЭЭ
- МЕССЕЖ ҮЙЛЧИЛГЭЭ
- **ОНЛАЙН ХАЙЛТЫН СИСТЕМ зэрэг** олон шинэлэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд дээрх үйлчилгээнүүд нь олны талархалыг хүлээсэн ажил болоод байна.

Мөн цаашид иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлд илүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ОЮУНБАЯР